

Ажлын хуудас

1. Дөлний өнгийг шараар буддаг химийн нэгдэл аль нь вэ?

A. NaCl

B. KCl

C. CuCl₂

D. BaCl₂

2. Галидын усан уусмалд мөнгөний нитрат нэмэхэд гарах үр дүнг тохируулна уу.

Галидын нэр

Туршилтын үр дүн

1 фторид

A цагаан тунадас

2 хлорид

Б цайвар шар тунадас

3 бромид

В шар тунадас

4 иодид

Г тунадас үүсэхгүй

3. Хуурай дээж **A** шинжлэхдээ дээжийг усанд уусгаад үүссэн уусмалыг мөнгөний нитратын уусмалаар үйлчлэхэд шар өнгөтэй тунадас үүсгэсэн, мөн дөлний өнгийг тоосгон улаан өнгөөр буддаг.


1. **A** нэгдэл ямар катион агуулсан бэ?

2. **A** нэгдэл ямар анион агуулсан бэ?

3. **A** нэгдлийг нэрлэнэ үү.

4.

Сурагч агаараас хүнд хийг гарган авч, хатаахаар дараах багажийг угсарчээ.



а) Зурагт өгсөн хоосон зайд харгалзах багаж, хэрэгслийг нэрлэнэ үү. 3 оноо